



МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД
С.АМАРСАЙХАН ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛТ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreatcouncil@parliament.mn
http://www.parliament.mn

2022. 04. 05 № 12

Г Асуулт тавих тухай

Дэлхий нийтийг хамарсан Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын улмаас Монгол Улсын эдийн засаг 1992 оноос хойших хамгийн гүн хямралд орж 2020 онд 4.6 хувиар агшсан байна.

Гадаад, дотоод худалдаа, үйлчилгээ нээгдэж, эдийн засаг аажмаар сэргэж байгаа ч уул уурхайн бүтээгдэхүүний экспорт, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн, шатахуун импортоос ихээхэн хамааралтай манай улсын зарим хилийн боомт хаагдаж, цөөн тооны боомт ажиллах болсны улмаас бизнес эрхлэгч аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд тодорхой бус байдал хэвээр байна.

Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт тус тус заасныг үндэслэн Танд дараах асуултыг тавьж байна. Үүнд:


1. Манай улсын худалдааны голлох боомтуудын үйл ажиллагааны талаар мэдээлэл өнөөгийн байдлаар;
2. Хилийн боомтуудын үйл ажиллагаа хэвийн явуулах, нэвтрүүлэлтийг эрчимжүүлэх хүрээнд ямар арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаа талаар мэдээлэл;
3. Импортын бараа бүтээгдэхүүний өртөгт хүчтэй нөлөөлж буй тээвэр, логистикийн асуудлын өнөөгийн байдал, тулгамдсан асуудал, түүнийг шийдвэрлэх хүрээнд богино хугацаанд авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар;
4. Зарим хаалттай хилийн боомтуудын үйл ажиллагааг хэзээ хэвийн байдалд оруулах зэрэг асуудлаар тодорхой мэдээлэл өгнө үү.

Асуултын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэгт заасан хугацаанд ирүүлэхийг Танаас хүсье.

Хүндэтгэсэн,

МОНГОЛ УЛСЫН ИХ
ХУРЛЫН ГИШҮҮН

Х.ГАНХУЯГ



2022000035